

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Люкс Занаду Групп ХК нь өнгөрсөн хугацаанд мэдээлэл технологийн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд 2023 оноос стратегийн томоохон хэлцлүүд явагдаж, бүтцийн томоохон өөрчлөлт хийгдсэн. Улмаар компанийн үйл ажиллагаанд нилээдгүй өөрчлөлт орж уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх болсон билээ.

2023 онд бид уул уурхайн бус экспортын төлөөлөл компаниудтай хамтран ажиллах талаар санал солилцож хэлэлцээрийг амжилттай эхлүүлсэн. 2023 оны 2-р улирал хэлэлцээр амжилттай өрнөж, дэлхийн зах зээлийн нөхцөл байдлыг судлах шатандаа явж байна. Уг хэлэлцээрийн үр дүн Люкс Занаду Групп ХК нь уул уурхайн бус экспортын компаниудыг нэгтгэж, нэгдсэн бодлогоор хангах толгой компани болох юм.

Компанийн нийтэд зарласан 82,871 ширхэг хувьцааг нийт 14 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бөгөөд 2 нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэйгээр 2023 оны 2-р улирал дууслаа.

2023 оны 1-р улиралд компанийн санхүүгийн үзүүлэлтэд өөрчлөлт ороогүй буюу компанийн эргэлтийн хөрөнгийн дүн 22.5 сая төгрөг. Үүнээс 2.9 сая төгрөг нь мөнгөн хөрөнгө ба 19.6 сая төгрөг нь дансны авлага байна. Эргэлтийн бус хөрөнгийн 32.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй. Нийт хөрөнгийн дүн 54.8 сая төгрөг. Нийт өр төлбөрийн дүн болох 14.7 сая төгрөг нь богино хугацаат өр төлбөр ба үүний 6.3 төгрөг нь дансны өглөг, 2.4 сая төгрөг нь НДШ-ийн өглөг, 6 сая төгрөг нь урьдчилж төлсөн орлого байна. Эздийн өмчийн хувьд өөрчлөлт байхгүй ба 6.3 сая төгрөг байна.

Ирэх улирлуудад хэлэлцээрийн үр дүн гарч компанийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн сацуу ашиг ажиллагаа нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна.

ХҮНДЭТГЭСЭН,

ЛЮКС ЗАНАДУ ГРУПП ХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.СУГАРСҮРЭН

